



“УВС АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ӨРГӨТГӨЛИЙГ БАРИХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙД БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	
2.1 Төсөл хэрэгжих газар нутгийн хөрсөн бүрхэвч:	
2.2 Төслийн талбай орчмын тоосжилт, агаарын чанарын, уур амьсгалын тухай	
2.4 Төсөл хэрэгжих нутгийн ургамалжилт	
2.5 Төслийн талбайн амьтны аймаг	
2.6 Нийгэм, эдийн засгийн байдал	
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	
ЕС. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
АРАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	
АРВАННЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	
АРВАНХОЁР. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	
АРВАНГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	
АРВАНДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ	

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-6 Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хэсгийн хүрээнд Увс аймгийн төв Увс хот Улаангом сумын 1-р багийн нутагт хэрэгжих “Увс аймгийн нэгдсэн эмнэлэг” баригдах төсөл юм.

Нэгдсэн эмнэлгийн барилга нь 1 хэсгээс бүрэлдсэн хуучин барилга дээр коридор дээр холбосон төв байр нь 3 давхар, баруун талын жигүүр нь 1 давхар энэ 1 хэсгийг холбосон хүзүүвч нь 1 давхар барилга. Давхар тус бүр нэг түвшингийн 3 метрийн өндөртэй. Том хэмжээтэй танхим байхгүй. Төв байр урагшаа 3, хойшоо 4 гарцтайгаас 2 гарцыг нэмж өргөтгөсөн. Тус барилга нь бетонон суурьтай 61 см зузаан тоосгон ханатай бетонон хавтан хучилттай, хар цаасан дээвэртэй. Эмнэлгийн эмчилгээний А корпус нь 3 давхар нийт 25 өрөөтэй, Б корпус нь 2 давхар 25 өрөөтэй. Нийтдээ 2640 м.кв талбайтайгаас ашигтай талбай 2600 м.кв. Эмнэлгийн гал тогоо болон төв байрыг холбосон хонгил галлерейтэй. Суурь болон дээврийн хэсэгтээ техникийн давхар болон подвал хонгилтой. Инженерийн шугам сүлжээг хонгилын системээр шийдсэн.



Зураг 1.1 Нэгдсэн эмнэлгийн хиймэл дагуулын зураг

1.1 Төсөлд хамрагдаж буй эмнэлгүүд: Нийслэлийн Эрүүл Мэндийн Газраас УБ хотод үйл ажиллагаа явуулж буй АЭМТ-үүдийн байршил, ачаалал, үйлчилгээний хамрах хүрээ зэргийг тооцон үзсэний үндсэн дээр дараах 4 өрхийн эмнэлгийг сонгон авч төслийн 1-р үе шатанд хамруулахаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 1.1 1-р үе шатанд хамруулахаар шийдвэрлэсэн өрхийн эмнэлгүүд

№	Эмнэлгийн нэр	Хийгдэх ажил
1	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	660 м2 талбай бүхий өргөтгөл барина
2	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	2400 м2 талбайг хамарсан барилгын ажил хийгдэнэ



Зураг 1.2 Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн ерөнхий харагдах байдал

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙД БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих газар нутгийн хөрсөн бүрхэвч:

Монгол орны физик газарзүйн мужлалаар Алтайн нурууны салбар уулс, Уулын хээрийн хөрс газарзүйн бүсээр Уулын хүрэн хөрсний бүсэд багтана. Төслийн хүрээнд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийг 2078 м² талбайд барьж байгуулах бөгөөд тус байгууламж нь эмнэлгийн барилга, гадна зам талбай, ногоон байгууламж зэрэг хэсгээс бүрдэнэ. Төсөл хэрэгжих талбай нь эргэн тойрон гэр хороолол, орон сууцны хорооллууд, хатуу хучилттай замаар хүрээлэгдсэн бөгөөд энэ орчмын хөрсөн бүрхэвч нь хүний олон жилийн үйл ажиллагааны нөлөөлөлд бүрэн өртсөн байдалтай байна. Гудамж хоорондох зам талбайн газар нь автомашин ба хүний хөдөлгөөний нөлөөгөөр хөрсний эвдрэл ихтэй, хөрсөн бүрхэвчийн элэгдэл явагдаж суларсан зэрэг нийтлэг байдал ажиглагдаж байна.

2.2 Төслийн талбай орчмын тоосжилт, агаарын чанарын, уур амьсгалын тухай

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөл барих газар нь Улаангом хотын төвд орших бөгөөд тус аймгийн агаарын бохирдол харьцангуй их бүсэд оршдог юм. Тухайн эмнэлгийн ойр орчим гэр хорооллын бүсийн захад байрлах бөгөөд жижиг хэмжээний бохирдуулагч эх үүсвэрийн нөлөөгөөр зундаа тоосжилт, өвөлдөө нүүрстөрөгч, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг бохирдуулагч бодис орчны агаарт тархаж, агаарын бохирдлын эх үүсвэр болдог байна. Төсөл хэрэгжих талбайд хамгийн ойр байрлах Увс аймгийн Улаангом сумын агаарын чанарын 1-р харуулын 2018-2023 оны 9 дүгээр сарын ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг Агаарын чанарын MNS 4585:2007, 2016 стандарт дахь хүлцэх хэмжээтэй харьцуулвал агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 4-7 мг/м³-д хүрч 1.4-2.5 дахин доогуур сарын дундаж агууламж 2-14 мг/м³ хүрч 4.4-31.1 дахин их, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 26-35 мг/м³-д хүрч 1.1- 1.5 дахин доогуур сарын дундаж агууламж 19-26 мг/м³-д хүрч 95-130 дахин их, PM10 буюу том ширхэглэгт

тоосонцрын жилийн дундаж агууламж 62-79 мг/м³-д хүрч 1.2-1.6 дахин их сарын дундаж агууламж 10-168 мг/м³-д хүрч 100-1680 дахин их үзүүлэлттэй байсан. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд төсөл хэрэгжих орчны агаарын чанарын суурь нөхцөл байдлыг “бохирдолтой” гэж үнэлсэн байна.

2.3 Төсөл хэрэгжих орчны гадаргын усан сүлжээний суурь нөхцөл байдал

Увс аймгийн нэгдсэн эмнэлэг төслийн талбай, түүний орчмын бүс нутгийн гадаргын усан сүлжээ нь Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд орших бөгөөд байнгын урсгалт Сагил болон Хархираа голууд байдаг. Мөн Монголын хамгийн том нуур болох Увс нуур 28.5 км зайтай оршдог. Харин хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед урсацтай болдог хуурай сайр жалгууд нь ус зүйн хувьд урьд өмнө судлагдаж байгаагүй болно. Нэгдсэн эмнэлгийн барилга барих төслийн талбай нь Хархираа голын усны онцгой хамгаалалтын бүсийн гадна байрлах бөгөөд төслийн үйл ажиллагаанаас гадаргын усанд үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл байхгүй юм.

2.4 Төсөл хэрэгжих нутгийн ургамалжилт

Төслийн талбайн ургамлан нөмрөгийн хувьд Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Их нууруудын хотгор тойрогт хамаарагдана. Энэ нутгийн уулын хоорондын өргөн уудам хөндийн ёроол ба тус тойргийн захын хэсэгт ялангуяа өмнө болон баруун өмнөт хэсэгт алаг өвс-шивээт хялганат юмуу дан шивээт хялганат бүлгэмдэлүүд түгээмэл тохиолдоно. Уулсын олон тооны ам хөндий улалжит ба алаг өвст-үетэнт, үетэнт нугаар үе үе солигдох мод- бургасан шугуй зурваслан үргэжилнэ. Улаангомын район нь Увс нуурын өмнө, баруун хэсгийн хуурай сайр болон голын голдролоор хэрчигдсэн налуу тал газрыг хамарна. Голын голдрол нь хайргархаг чулуу ихтэй бөгөөд сийрэг улмасан төгөл, зарим газраараа тачир ургамал бүхий нугын бүлгэмдэлтэй. Энэ районд Зүүнгар-баруун монголын таарт болон шарилж-дэгнүүлт үетэн-таарт хээржүү цөл зонхилдог. Уулын хаяа руу таарт, шарилжит бүлгэмдэлтэй хам нэгдэл үүсгэсэн дэгнүүлт үетэн-хялганат Зүүнгар-баруун монголын хэвшинжийн цөлжүү хээр тархаж, улмаар баруун монголын агь-ерхөг-хялганат юмуу ерхөгт хуурай хээрт шилжинэ.

Нэгдсэн эмнэлгийн ойр орчимд ургамлан нөмрөг нь нэлээд өөрчлөгдсөн, хүн ам суурьшсан бүсийн суурьшилт олон жилийн өмнөөс эхэлж унаган зүйлүүд устсан бөгөөд энд шарилжийн төрлийн, луулийн төрлийн ургамалууд тохиолдохоос гадна, ихэнхи ургамалын амьдарлын байдал нь муу тачир сийрэг, намхан, зүйлийн бүрдлийн хувьд цөөн байгаа нь энэ газар талхагдалд их өртснийг харуулж байна. Ялангуяа талхлаг индикатор болох шарилжууд нэлээд байгаагаас гадна ургал эрхтнүүдээрээ үрждэг үетэн, үрээр үрждэг нэг настууд дэд зонхилогчийн үүрэг гүйцэтгэж байна. Түүнчлэн ургамлан нөмрөгт зогдор улалж, сибирь өлөнгө, шүлхий шарилж зэрэг ургамал тохиолдох ба улалж өвсний бүл элбэг тохиолдоно. Энэ орчимд ховор болон нэн ховор зүйлийн ургамал ургадаггүй.

2.5 Төслийн талбайн амьтны аймаг

“Нэгдсэн эмнэлэг барьж байгуулах” төслийн талбай нь Увс аймгийн төв хэсэгт суурьшлын бүсэд орших бөгөөд төслийн талбай орчимд амьтны аймгийн амьдрах нөхцөл аль хэдийнээ алдагдагджээ. Төслийн талбайд 2024 оны 4 сард хийгдсэн “Натуралист” ХХК-ийн хийсэн амьтны аймгийн судалгаагаар тус төсөл хэрэгжих, түүний орчмоор амьтан тэмдэглэгдээгүй байна. Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанаас амьтанд үзүүлэх сөрөг нөлөө байхгүй. Харин уг эмнэлгийн барилга баригдсаны дараа шувуудаас хүнд ойромсог (синантроп) зүйлүүд барилга байгууламжид үүрлэж болзошгүй.

2.6 Нийгэм, эдийн засгийн байдал

Төслийн хүрээнд баригдах Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн хүрээнд нийгмийн сайн сайхны төлөө үйлчлэх зорилго бүхий байгууламж бөгөөд ашиглалтад орсноор Увс аймгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар дээшлэх юм.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөл барьж байгуулах” төсөл хэрэгжсэнээр тус аймгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар дээшлэх бөгөөд гурав дахь шатлалд төвлөрөөд буй ачааллыг сааруулах, цаашлаад иргэд гадаадад эмчлүүлэхээр олноор явж буй урсгалыг сааруулахад тодорхой хувь нэмэр оруулна.

Төсөл хэрэгжих газарт олон төрлийн байгаль орчин, нийгмийн судалгааг хийж, тэдгээрийн үр дүн ба нийгмийн байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл, ЕҮД-д заагдсан чиглэл, удирдамжид үндэслэн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр нь тодорхойлон үнэлж, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг төлөвлөж өгсөн.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нийт 56 гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг олж тогтоосон бөгөөд үүнээс 73% нь шууд, 27% нь шууд бус нөлөөлөл байна. Нийт сөрөг нөлөөллийн 9% нь маш бага, 55% нь бага, 36% нь дунд гэсэн ангилалд хамаарч байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж байгаа нөлөөллүүд нь үргэлжлэх хугацааны хувьд 18% нь түр зуурын, 82% нь богино хугацааны нөлөөлөл байна.

Хүснэгт 3.1 Төслийн байгаль орчны сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөлөл		Нөлөөллийн зэрэглэл	
		Гол	Болзошгүй	Үнэлгээгээр тогтоосон нөлөөллийн зэрэглэл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсний дараах нөлөөллийн зэрэглэл

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Газрын гадарга, хэвлий	3	-	Дунд	Бага
2	Агаарын чанар	3	2	Дунд	Бага
3	Физик нөлөөлөл	3	2	Дунд	Бага
4	Гадаргын ус	2	2	Бага	Маш бага
5	Газрын доорх ус	-	2	Бага	Маш бага
6	Хөрсөн бүрхэвч	2	3	Дунд	Бага
7	Ургамлан нөмрөг	-	-	-	Эерэг
8	Амьтны аймаг	-		-	-
9	Тусгай хамгаалалттай газар нутаг	-	-	-	-
10	Түүх, соёлын өв	-	1	Маш бага	Маш бага
11	Нийгэм, олон нийт, хүний эрүүл мэнд аюулгүй байдал	3	12	Дунд	Бага
Төслөөс үзүүлэх нийт нөлөөллийн нийлбэр үнэлгээ		16	40	Дунд	Бага

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болох Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй Төсөл Хэрэгжүүлэх Нэгж хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага хүлээнэ.

БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллага нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 29.370.000 төгрөг болно.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах								
Газар шорооны ажилд 0.21 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	1033 м ² талбайд ногоон байгууламж байгуулж, мод зүлэг тарьж тохижуулна.	Барилгын ажилд өртөж эвдэрсэн талбай	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан				2025-2026 онд Барилга угсралтын ажил дууссаны дараа	MNS 5918:2008 Байгаль орчин, Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
Барилгын суурь ухах газар шорооны ажлаас 2600 м ³ хаягдал шороон материал үүсэх	Хаягдал шороон материалыг Улаангом сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг сумын захиргаанаас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө.	Газар шорооны ажил явагдах цэгүүд, шороон материалын овоолго	Үйл ажиллагааны зардалд багтсан				2025-2026 онд Газар шорооны ажил явагдах хугацаанд	Хог хаягдлын тухай хууль, Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент,
	Хаягдал шороон материалыг их хэмжээгээр хуримтлуулалгүйгээр тухай бүрт зайлуулж байх							
	Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын ялгарал,	Газар шорооны ажил явагдах	Үйл ажиллагааны зардалд багтсан					

	овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж ажиллана.	цэгүүд, шороон материалын овоолго						ашиглалтын дүрэм
Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	Газар шорооны ажлаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ нийтийн эзэмшлийн зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох	Газар шорооны ажил явагдах цэгүүд, шороон материалын овоолго	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан				Газар шорооны ажил явагдах хугацаанд	MNS5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
	Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх	Газар шорооны ажил явагдах цэгүүд, шороон материалын овоолго						
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Барилгын суурь ухах, талбайн цэвэрлэгээ тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах	Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох	Барилгын ажлын талбай	Усны хэмжээ тонн, хучлага м2	702м3	3000	1 жилийн усалгааны зардал 404,000*2= 808,00	2025-2026 онд Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
	Хүчтэй салхи шуургатай үед шороон материалын овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж хүчиж бүтээх							

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх							
	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд 2640 м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	Барилгын ажлын талбай		702м3	3000			
Авто машин бусад тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал ялгарна.	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	ОХШХ-т тусган оруулсан				2025-2026 онд	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
	Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношлогоо үйлчилгээг тогтмол, чанартай хийлгэх						MNS4990:2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ	
	Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах						Барилгын ажлын туршид, 7 хоног бүр	MNS4990:2000 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

Барилга угсралтын ажлын үед цемент, шохой зэрэг нунтаг бодисууд, мотөрийн үртэс, хаягдал материалууд салхинд дэгдэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй.	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Барилгын ажлын талбайд	Үйл ажиллагааны зардалд багтсан				7 хоногт 1-2 удаа	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Газар шорооны жил, барилга угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах зэрэг ажлуудаас дуу чимээ үүсэх	Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд Барилгын ажлын талбай	2	Жилд 6 удаа	200,000	1,200,000	2025-2026 онд Барилгын ажлын туршид	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл
	Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх							
	Дуу чимээний хяналт тавих							
Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	Улаангом сумын тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах	Барилгын ажлын талбай	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.				2025-2026 онд Барилгын ажлын туршид	MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
	Барилгын түр кэмпэд ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож.							

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Барилгын ажлын талбай	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.				2025-2026 онд Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл.
	Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох							
	Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх							
	Барилгын ажил явагдаж буй газруудад зориулалтын хогийн сав байрлуулах							
	Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих							
Гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Хог хаягдлыг замбараагүй зайлуулснаас үүдэн хур борооны усаар Толгойтын горхи руу зөөгдөх буюу Хүний хайхрамжгүй үйл ажиллагаанаас шалтгаалан Толгойтын горхи орчимд гадаргын усны бохирдол үүсгэж болзошгүй.	Ахуйн ба барилгын хог хаягдал түр хадгалах цэгийг хашаажуулж, хог хаягдал үерийн усаар зөөгдөхөөс сэргийлэх	Эмнэлгийн барилгын ажил явагдах талбай орчимд	синтетик шингээгч материал (TSSW50W), ширхэ	3	50.000	150.000	2025-2026 онд Барилгын ажлын туршид	Усны тухай хууль MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Барилгын ажлын явцад шатах, тослох материал асгарч хөрсөнд шингэн,	Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус							Усны нөөцийн төлбөрийн хувь хэмжээг тогтоож, хөнгөлөх тухай

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

улмаар бага гүний уст үеүдийг дам хэлбэрээр бохирдуулж болзошгүй	ашиглалтын гэрээ байгуулж ажиллах	Барилгын ажил явагдах талбайд	Үйл ажиллагааны зардалд багтсан				Барилгын ажлын туршид	Засгийн газрын тогтоол
	Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах							MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй ба
Барилгын түр кемпийн үйл ажиллагаанаас үүсэх шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт дам байдлаар нөлөөлж болзошгүй.	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Барилгын ажил явагдах талбай	Барилгын ажлын үеийн хог цэг бий болгож ариутгал тогтмол хийх	10 удаа	50.000	500.000	Газар шорооны ажил явагдах хугацаанд	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
	Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх							Ариун цэврийн тухай хууль
Газар шорооны ажлын үед хөрсний усны шүүрэл үүсч болзошгүй	Шүүрлийн усыг зайлуулах дренажийн ажлын зураг төслийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Барилгын түр кемп					7 хоног бүр	
	Дренажийн ажлын авч хэрэгжүүлэх БОМТ-г тусад нь боловсруулж НБОГ-аар батлуулах		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан					Хот суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хууль
				5				

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ					
Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрсний элэгдэл, доройтол үүсэх	Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах	Барилгын материал тээвэрлэх зам дагуу, барилгын талбай барилгын түр кемпүүд	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан	Барилгын ажил дууссаны дараа 2025-2026 онд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль,
	Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх				MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Барилгын суурь ухах ажлаар 660 м2 талбайн өнгөн хөрс хуулагдах ба хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанарт өөрчлөлт гарч болзошгүй	Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед гадна орчны тохижилт, нөхөн сэргээлтэд ашиглах	Барилгын ажлын талбай		Газар шорооны ажил явагдах хугацаанд	
Хог хаягдал, кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсч болзошгүй	Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Барилгын түр кемп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.	2025-2026 онд	MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл.
	Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох				
	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж,				

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх							
	Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх							
Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Эмнэлгийн хойд хэсгийн шимт хөрс хуулагдана. Үүнтэй хамт ургамлан нөмрөг устах болно	Ногоон байгууламжийг зөвлөмжийн дагуу боловсруулах, орчныг тохижуулах	Эдэлбэр газар	Хөрөнгө оруулалтын зардал				2025-2026 онд	Газрын тухай хууль, 56.6
Нийт						2.658.000		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад хууль тогтоолын дагуу Нэгдсэн эмнэлэг барих үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт /MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008/-ын дагуу хийсэн байх үүрэгтэй. Нөхөн сэргээлтийн ажлын зардлуудыг “Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2015 оны 03 сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалын хавсралт болох нөхөн сэргээлт хийгдэх ажлын үнэлгээ тооцох аргачлал”-ын дагуу тооцоолсон болно.

Увс аймгийн нэгдсэн эмнэлэг барих барилгын үйл ажиллагаа дуусмагц эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлтийг хийнэ. Нөхөн сэргээлт хийсний дараа 1 жил мониторингийн үйл ажиллагаа явуулна. Энэ нь нөхөн сэргээлт хийсэн талбай ургаж байгаа эсэхийг хянах зорилготой юм.

Нэгдсэн эмнэлэг барих барилгын ажлын үед 2.4 мян.м.кв-д талбайд газар шорооны ажил хийгдэнэ. Тухайн ажил хийгдэж дууссаны дараа барилгын талбайн ойролцоо эвдэрсэн болон талхагдсан газарт нөхөн сэргээлтийн ажил хийнэ. Ногоон байгууламжид 17 ширхэг гацуур мод, 10 ширхэг монос, 15 ширхэг бут сөөг, улиас 17 ширхэг мод тарихаар төлөвлөсөн болно.

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын явцад эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрс ачих, тээвэр, хучих ажлын зардал /Утгуурт ачигч, автосамосвал	Нэгдсэн эмнэлгийн барилга баригдаж дууссаны дараа тухайн орчмын нөхөн сэргээлт	1440м ³	911	1,311,700	Барилгын ажлын үед 2025-2026онд	Барилгын гэрээт гүйцэтгэгч	MNS:5916:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.4, MNS 5917:2008. Техникийн ерөнхий шаардлага
2	Биологийн нөхөн сэргээлт	Зүлэгжүүлэх ажлын зардал		1033 м ²		5,579,000	2025	Барилгын гэрээт гүйцэтгэгч	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага
		Мод тарих ажлын зардал		23ш	111.000	2.553.000	2025		
	Нийт					9.443.700			

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нийгмийн барилга байгууламж баригдах талбай, тэдгээрийн ойр орчимд түүх, соёлын өв, дурсгалт газрууд байхгүй болох нь төсөл хэрэгжих талбайд хийгдсэн судалгааны явцад БОННУ-нд тогтоогдсон. Иймд энэхүү төсөлд түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлага байхгүй болно.

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга нь одоо байгаа нэгдсэн эмнэлгийн эзэмшил газар дотор баригдах бөгөөд бусад газар ашиглагчдын зөвшөөрөл бүхий газартай давхцахгүй. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

ЕС. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1. Байгалийн аюул, гамшигт нөхцөл байдал							
1	Үерийн эрсдэл	Барилгын талбай ба ажилчдын түр кемп, шороон материалын овоолгыг үерт өртөхөөргүй газарт сонгож байршуулах	Барилгын талбай, түр кемп, материалын агуулах, шороон материалын овоолго	Үйл ажиллагааны зардалд багтсан		Барилгын ажлын туршид 2024-2026	Усны тухай хууль, Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.03
		Барилгын суурь, шуудуу ухах зэрэг газар шорооны ажлыг хур борооны улирлаас урьтаж хийж дуусгах					
		Гамшгаас хамгаалах Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж холбогдох байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх					
		Шинээр баригдах эмнэлгийн барилга байгууламжуудад үерээс хамгаалах систем төлөвлөж өгөх					
2	Газар хөдлөлтийн аюул, эрсдэл	Онцгой байдлын үед гамшгаас хамгаалах арга хэмжээ авах талаарх сургалтад барилгын ажилчид, инженерүүдийг хамруулах	Бүх барилгын ажилчид, инженерүүд	500.000	500.000	Барилгын ажил эхлэхээс өмнө	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Газар хөдлөлтийн үед цугларах цэг тогтоож, самбар байршуулах	Барилгын талбай	50.000	50.000		

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

8	Газар хөдлөлтийн аюул, эрсдэл	Онцгой байдлын үед гамшгаас хамгаалах арга хэмжээ авах талаарх сургалтад барилгын ажилчид, инженерүүдийг хамруулах	Эмнэлгийн ажилчид, инженерүүд	300.000	300.000	2025	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Газар хөдлөлтийн үед цугларах цэгийн ойр орчмын аюулгүй зорчих хэсгийн шинэчлэн тогтоох		200.000	200.000	2025	
9	Гал түймрийн аюул эрсдэл	Галын пункт байгуулж гал унтраах багаж төхөөрөмжөөр хангаж. Галын сарай, галын хорын хяналтыг тогмол хийх	Эмнэлгийн талбайд	500.000	500.000	2025	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль
	Нийт:				1.550.000		

АРАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Хог хаягдлын менежментийн арга хэмжээ	Тоо хэмжээ	Нийт өртөг	Нийт зардал	Хэрэгжүүл эх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Ахуйн хог хаягдал	Аймгийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт тээвэрлэн хүргэх ажлыг гүйцэтгүүлэх	10	50.000	500.000	7 хоногт 2 удаа	Хог хаягдлын тухай хууль
2		Барилгын түр кэмпэд ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	1	500.000	500.000	Барилгын ажил эхлэхээс өмнө	
3		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох	Үйл ажиллагааны төсөвт багтсан			Барилгын ажилын туршид	Хог хаягдлын тухай хууль
4		Барилгын ажил явагдаж буй газруудад зориулалтын хогийн сав байрлуулах					Ариун цэврийн тухай хууль
5		Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх					MNS 5344 : 2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
6		Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	1	1.000.000	1.000.000		
7		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих	Үйл ажиллагааны төсөвт багтсан				
8	Барилгын хог хаягдал	Барилгын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хэрэгцээ, төрлөөр нь ангилан ялгана.	Үйл ажиллагааны төсөвт багтсан			Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах,
9		Барилга, байгууламж, явган хүний зам талбай, ногоон байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, тоноглох, буулгахад үүсэх хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, талбайг чөлөөлнө.					

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

10		Барилгаас үүссэн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг зайлуулах зөвшөөрлийг Улаангом сумын Засаг даргаас авч, хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэн зайлуулна.					устгах, булшлах журам
11		Барилгын хог хаягдал тээвэрлэх машиныг Аймгийн нэгдсэн GPS-ийн хяналтын системд бүртгүүлсэн байх	Үйл ажиллагааны төсөвт багтсан			Барилгын ажлын туршид	MNS BS 5906:2015 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм
12		Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газар хаяхгүй байх					
13		арилгын хог хаягдал тээвэрлэх тэвштэй буюу өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл нь хог хаягдлыг гээгдэхээс хамгаалах зориулалтыг хэрэгсэлтэй, өндөрлөгөө, хашлага, бүтээлэгтэй байх					
14	Хаягдал шороо, материал	Барилгын суурь ухах ажлаас үүсэх 1003 м3 хаягдал шороон материалыг Улаангомьын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Улаангом сумын захиргаанаас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгөх	Үйл ажиллагааны төсөвт багтсан			Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, даихн боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам
15		Хаягдал шороон материалыг их хэмжээгээр хуримтлуулалгүйгээр тухай бүрт зайлуулж байх					
16		Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын ялгарал, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтлөх					
17	Эмнэлгийн хог хаягдал	Эмнэлгийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгах	12	100.000	1.200.000	Эмнэлгийн үйл ажиллагааны туршид	Эрүүл Мэндийн Сайдын А/230 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах,
18	Энгийн хог хаягдал	Энгийн хог хаягдлыг хар өнгийн хогийн уутанд цуглуулах	Эмнэлгийн үйл ажиллагааны төсөвт багтсан.				
19		Дахивар нөөц хаягдлын уутан дээр цувраа 3 сум бүхий дахин боловсруулалтын тэмдгийг байршуулах					
20	Аюултай хог хаягдал	Био-аюултай таних тэмдэг бүхий гурвалжин таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулах	132	50.500	6.666.000		

Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийг барих” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

21		Халдвартай хог хаягдлыг “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”-ийн 1-р хавсралтын 1.3.1, 1.3.2, 1.3.3, 1.3.4, 1.3.5, 1.3.6 т заасны дагуу цуглуулж, хадгалаж, халдваргүйжүүлж, зайлуулж, устгана.					тээвэрлэх, боловсруулах, устгах заавар”
22		Эмнэлгийн аюултай хог хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх					
	Нийт		9.866.000				

АРВАННЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	8
1	Агаарын чанар SO ₂ , NO ₂ , PM ₁₀ , PM _{2.5}	Эмнэлгийн өргөтгөл барилга барих хэсэг болон авто зогсоол орчим	Улирал тутамд	2 цэгт	100.000	800.000	MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2010 Агаарын чанар - Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2000 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2	Дуу чимээ		Улирал тутамд	2 цэгт	25.000	100..000	MNS4585:2016 Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ MNS4995:2015 Ажлын орчинд дуу чимээний давтамж болон хэлбэлзэл
3	Хөрсний чанар	Барилгын ажлын талбай, ажилчдын түр кемп	Улирал тутамд	2 цэгт	100.000	800.000	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Ундны усны чанар	Унд ахуйн хэрэгцээнд ашигласан буй төвлөрсөн шугам	Улирал тутамд	1 цэгт	150.000	600.000	MNS0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
5	Эрүүл ахуйн хяналт шинжилгээ	Эмнэлгийн хог хаягдал цуглуулах цэг	Улирал тутамд	1 цэгт	150.000	600.000	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага. MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
	Нийт:					2.900.000	

АРВАНХОЁР. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар...	Сар...	Сар...		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	-	2025 оны 1–р улиралд багтаан батлуулна.			Байгаль орчны мэргэжилтэн	
2	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр барилгын ажилчдыг чадавхижуулах	-	ХХАА-ны ээлжит болон шинэ ажилтны зааварчилгаа бүрт			Байгаль орчны мэргэжилтэн	
3	Мод тарих үндэсний өдөрт ажиллагсдыг хамруулж мод тарих		2025 оны 10-р сард			Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт						2.553.000

АРВАНГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн захиргааны төв байгууллагууд /Орон нутгийн БОАЖГ, бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар	Бичгээр хүргүүлэх, Хурал зохион байгуулах	БОМТ-ний хэрэгжилт	11 сарын 1-ны дотор	200.000	Төслийн удирдлага	Төсөл хэрэгжүүлэгч
2	БОАЖЯ-нд жилийн эцэст А/618 журмын дагуу орон нутгаас төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлтийг авч хавсарган төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлнэ.	Бичгээр хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилт	12 сард	-	Байгаль орчны мэргэжилтэн	Төсөл хэрэгжүүлэгч
3	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	Хурал өдөрлөг зохион байгуулах	БОМТ-ний хэрэгжилт	9-10 сард	200.000	Байгаль орчны мэргэжилтэн	Төсөл хэрэгжүүлэгч
	Нийт				400.000		

АРВАНДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

Нийт 29 сая 370 мянган төгрөгний зардал гарна гэж урьдчилан тооцсон ба уг тооцсон зардал нь байгаль орчныг хамгаалахад гарах шууд зардлаар тооцож байгаа ба зарим тохиолдолд хаягдлыг дахин ашиглана гэж үзсэн.

№	Байгаль орчны бүрдэлүүд	Зардал /сая.төг/
Тухайн жилийн нийт зардал		29.370.000
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2.658.000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	9.443.000
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1.550.000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	9.866.000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2.900.000
6	Тухайн жилийн байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2.553.000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөө	400.000